



Ховд аймагт хөрөнгө оруулагчдын чуулганд зориулав.

Ховд аймаг – Монгол улсын хөгжлийн баруун үүд

Ачаа тээврийн логистик төв барих төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Ачаа тээврийн логистик төв
Байршил	Аймгийн төв-үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Ховд аймаг нь баруун бүс нутагтаа олон хүн амтай, хамгийн нягт суурьшилтай төдийгүй гадаад, дотоод, мөн дамжин өнгөрөх худалдаа, тээврийн үндсэн зангилаа болох боломжтой байна. Бүс нутгийн ачаа тээврийг оновчтой зохион байгуулахад шаардлагатай орон зайн болон технологийн дэвшилтэт шийдэл гаргах, бараа нийлүүлэлт түгээлтэд тавих төр болон гаалийн хяналтыг зохион байгуулах боломжтой дэд бүтэц, орчныг бий болгох зүй ёсны шаардлага тулгараад байна. Өөрөөр хэлбэл худалдаа, тээврийг хөнгөвчлөх замаар бизнесийн хөгжлийг дэмжих, хотын орон зайн ба зам тээврийн төлөвлөлтийг илүү оновчтой болгох зорилгоор ачаа тээвэр логистикийн үйлчилгээг Ховд хотын орчимд нэгтгэн байгуулах шаардлагатай байна.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Ачааны терминалд 4 төрлийн ачаа боловсруулна. “Чингэлэг” – чингэлэгээр тээвэрлэдэг бүх төрлийн ачааг оруулна. Үүнд: хүнс, хагарах эд зүйл, барилгын материал, тоног төхөөрөмж, дугуй, машины эд анги сэлбэг гэх мэт хэрэглээний бусад зүйлс “Задгай ачаа” – чингэлэгээр бус нээлттэй тэвшээр тээвэрлэдэг барааг оруулна. Үүнд: цемент, тоосго, хүнс гэх мэт бүтээгдэхүүн орно. “Бүхэл ачаа” – металл, чулуу гэх мэт хатуулаг мөн цемент, гурил гэх мэт нарийн бараа орно. “Хүнд ачаа” – хүнд жинтэй, овор ихтэй бараа, тоног төхөөрөмж гэх мэт орно.
Зах зээлийн багтаамж	Судалгаагаар жилдээ орон нутаг, хот хоорондын тээврээр 96,1 мян.т, улс хоорондын тээврээр 181,2 мян.т ачаа тээсэн тооцоо байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Бүс нутгийн логистик тээврийг хөгжүүлэхээр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	
Үйлдвэрлэлийн хүчин чадал	С ангиллын жилдээ 100,0-300,0 мян.т ачаа боловсруулах

Жилийн борлуулалтын тооцоолол	Судалгаагаар жилдээ 277,3 мян.т ачаа боловсруулна.
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Иргэдийн авто тээврийн эрэлт хэрэгцээг хангаж, хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлсэн, хөдөлгөөний аюулгүй байдлын болон байгаль орчин, хүн амд сөрөг нөлөөгүй, орон нутгийн нийгэм эдийн засгийн нийтлэг эрх ашигт нийцсэн авто тээврийн оновчтой системийг бий болгоход чухал ач холбогдолтой юм.

Зорчигч тээврийн үйлчилгээний автовокзал барих төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Зорчигч тээврийн автовокзал
Байршил	Аймгийн төв
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Ховд аймаг нь баруун бүс нутагтаа олон хүн амтай, хамгийн нягт суурьшилтай, гадаад, дотоодын мөн дамжин өнгөрөх худалдаа, бизнес, аялал жуулчлалын төв болон хөгжиж байна. Бүс нутгийн зорчигч тээврийг оновчтой зохион байгуулахад шаардлагатай орон зайн болон технологийн дэвшилтэт шийдэл бүхий, нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаанд тавих төрийн үйлчилгээ, хяналтыг зохион байгуулах боломжтой дэд бүтэц, орчныг бий болгох зүй ёсны шаардлага юм. Ховд-Улаанбаатар чиглэлийн нийтийн тээврээр үйлчлүүлэгчдийн тоо жилээс жилд өсч байгаа, орон нутгийн зорчигч урсгал нэмэгдэж байгаа нь улс, хот хооронд, орон нутгийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний автобуудал байгуулж, тэдгээр үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангах гол зорилт болж байна.
Төслийн явц	ЗТЯ-д төслийн үндэслэл боловсруулагдсан. Нэг маягийн зураг төсөл нь бэлэн байгаа. Дархан, Сэлэнгэ аймгуудад автовокзал барьж ашиглалтад орсон.
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ
Зах зээлийн багтаамж	Судалгаагаар Ховд-УБ чиглэлийн нийтийн тээвэрт 40 гаруй ПАЗ маркийн 35 хүний суудалтай автобус жилдээ 20,0 мянга гаруй зорчигч, орон нутгийн нийтийн тээвэрт 120 гаруй тээврийн хэрэгсэл оролцож сардаа 9500, жилдээ 114,0 мянган хүн зорчиж байна. Иймд нэгдсэн автовокзал байгуулахад жилдээ 150,0 мянган зорчигч үйлчлүүлэх тооцоо гарч байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт туссан байгаа.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	Жишиг тооцооллоор 2.500,0 сая төгрөг
Үйлдвэрлэлийн хүчин чадал	-Автобуудлын байгууламж, тоног төхөөрөмж нь MNS 6300:2011 стандарт шаардлагыг хангасан байх -зорчигч урсгалын өдрийн дундаж тоо /тухайн жилээр тооцно/ 250 -аас 1000 хүн хүртэл -Нэг цагт үйлчлэх хамгийн их зорчигчийн тоо 50-аас 200 хүн хүртэл байх -Автобуудлын үйлчилгээний талбай 50 м ² -аас дээш байх нийтийн зориулалтын талбай 75 м ² -аас дээш байх -үйлчилгээний автобусны талбай нь 240 м ² -аас дээш байх
Жилийн борлуулалтын тооцоолол	Судалгаагаар жилдээ 150,0 мянган зорчигч үйлчлүүлэх тооцоо гарч байна.
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Иргэдийн автотээврээр зорчих эрэлт хэрэгцээг хангаж, хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлсэн, хөдөлгөөний аюулгүй байдлын болон байгаль орчин, хүн амд сөрөг нөлөөгүй, орон нутгийн нийгэм эдийн засгийн нийтлэг эрх ашигт нийцсэн автотээврийн оновчтой системийг бий болгоход чухал ач холбогдолтой юм.

Бетон зуурмагийн үйлдвэр байгуулах төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Бетон зуурмагийн үйлдвэр
Байршил	Аймгийн төв үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Ховд аймагт баригдаж байгаа барилга байгууламжийг стандартын шаардлага хангасан бетон зуурмагаар хангах. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд ашиг олох
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	M150, M200, M250, M300, M350 M450 маркын бетон зуурмаг
Зах зээлийн багтаамж	Одоогийн зах зээлийн судалгаагаар Ховд аймагт жилдээ ойролцоогоор 2030.0 мянган м ² барилга шинээр болон засвар үйлчилгээ хийгдэж байна. Үүнээс үзэхэд жилдээ 20000 м.куб бетон зуурмаг борлогдох боломжтой. Цаашид Засгийн газрын 100 мянган айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд Ховд аймагт 1000 айлын орон сууц шинээр баригдахаас гадна олон үйлдвэр үйлчилгээний барилга баригдах тул энэ хэрэглээ өсөх хандлагатай байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Засгийн газрын “100 мянган орон сууц” хөтөлбөрийн хүрээнд барилгын материалын үйлдвэрийг дэмжиж байгаа.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	Шинээр байгуулах 1000.0 сая төгрөг
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	1000.0 саятөгрөг
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Цагт 75 м.куб, өдөрт 600 м.куб бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай,
Жилийн борлуулалтын тооцоолол	Судалгааны дүнгээр жилд 20000 м.куб зуурмаг борлогдох боломжтой /зах зээлийн багтаамж нь/
Цэвэр ашгийн тооцоолол	Цэвэр ашиг нь 10 хувь
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Барилгын ажил улирлын чанартай учраас барилга угсралтын компаниудад цаг хугацаахүн хүч хэмнэх сайн талтай. Ховд аймагт үйл ажиллагаа явуулж байгаа барилга угсралтын комданиуд стандартын шаардлага хангасан бетон зуурмаг ашигласнаар чанартай барилга байгууламж зах зээлд нийлүүлнэ.

Ховд аймгийн Булган сумын төвлөрсөн дулаан хангамж төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Булган сумын Дулааны станц
Байршил	Ховд аймгийн Булган сумын нутагт
Үйлдвэрлэлийн хүчин чадал	20 мВт
Төсөл хэрэгжүүлэх хугацаа	2015 оноос 2017 он хүртэл
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Сумдад дулааны станц барьснаар сумын бүхийл байгууллага шинээр барих барилга байгууламж, зарим айл өрхүүд төвлөрсөн дулаан хангамжтай болно. Ингэснээр сумын ард иргэдийн таатай амьдрах орчин бүрдэж агаарын бохирдол буурч сумын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Булган сумын дулаан хангамж. Хөшөөтийн уурхай нь 270,2 сая тонн нүүрсний нөөцтэй болох нь одоогоор тогтоогдоод байгаа учир удаан хугацаандажиллах боломжтой.
Зах зээлийн багтаамж	Булган сумын төв нь 1000 гаруй айл өрх 40 гаруй албан байгууллага
Хууль эрх зүйн орчин	Монгол улсын УИХ, ЗГ, Эрчим хүчний яамнаас гаргасан Монгол улсын эрчим хүчний хөгжлийн хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан. Хөрөнгө оруулалт, Концесс, Эрчим хүчний болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.
Орон нутгийн дэмжлэг	Дулааны станц барих тал дээр орон нутгийн удирдлага болон ард иргэд бүрэн дэмжиж байгаа. Холбогдох зөвшөөрлийг саадгүй олгож, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын татварт хөнгөлөлт үзүүлж тогтвортой байдлын гэрээ байгуулан ажиллана.
Санхүүжилтийн хэлбэр	Концесс, Төр, хувийн хэвшил
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Булган сумын дулаан хангамж сайжирч ард иргэдийн таатай амьдрах орчин бүрдэнэ.Цаашид бүс нутагт томоохон хэмжээний үйлдвэр үйлчилгээ, уул уурхай хөгжихөд түлхэц болно гэж үзэж байна. Булган сумыг дулаанаар хангана.

**Чоно харайхын голын төмөр бетон гүүр шинээр
барих төслийн товч танилцуулга**

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Чоно харайхын голын төмөр бетон гүүр шинээр барих
Байршил	Ховд аймгийн Дөргөн сум Чоно харайхын гол
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Дөргөн сумын Агваш багийн 200 өрхийн өвөлжөө, хаваржаа, Говь-Алтай Улаангом чиглэлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн саадгүй нэвтэрнэ. Завхан аймгийн Дөрвөлжин сумын иргэдийн тээврийн хэрэгсэл нэвтэрнэ.
Төслийн явц	Зураг төсөв бүрэн хийгдсэн.
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Төмөр бетон гүүрээр жилдээ 2000 гаруй тээврийн хэрэгсэл саадгүй зорчино
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгийн иргэд, төрийн захиргааны байгууллага бүрэн дэмжиж байна. Холбогдох зөвшөөрөл саадгүй олгож, хамтран ажиллах санал санаачлагыг дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Концесс, төр, хувийн хэвшил
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	1 тэрбум 500 сая төгрөг
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	1 тэрбум 500 сая төгрөг
Үйлдвэрлэлийн хүчин чадал	36,8 у/м төмөр бетон гүүр, Даац 80т
Жилийн борлуулалтын тооцоолол	Жилдээ 2000 гаруй тээврийн хэрэгсэл зорчих судалгаа гарсан
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Дөргөн сумын Агваш багийн 200 өрхийн өвөлжөө, хаваржаа, ГовьАлтай Улаангом чиглэлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн саадгүй нэвтэрнэ. Завхан аймгийн Дөрвөлжин сумын иргэдийн тээврийн хэрэгсэл нэвтэрнэ.

Дарви суманд Зорчигч тээврийн үйлчилгээний автовокзал барих төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Зорчигч тээврийн автовокзал
Байршил	Ховд аймгийн Дарви сумын төв
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Ховд аймаг нь баруун бүс нутагтаа олон хүнамтай, хамгийн нягт суурьшилтай, гадаад, дотоодын мөн дамжин өнгөрөх худалдаа, бизнес, аялал жуулчлалын төв болон хөгжиж байна. Бүс нутгийн зорчигч тээврийг оновчтой зохион байгуулахад шаардлагатай орон зайн болон технологийн дэвшилтэт шийдэл бүхий, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд тавих төрийн үйлчилгээ, хяналтыг зохион байгуулах боломжтой дэд бүтэц, орчныг бий болгох зүй ёсны шаардлага юм. Ховд-Улаанбаатар БаянӨлгий-Ховд чиглэлийн нийтийн тээврээр үйлчлүүлэгчдийн тоо жилээс жилд өсч байгаа, орон нутгийн зорчигч урсгал нэмэгдэж байгаа нь улс, хот хооронд, орон нутгийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний автобуудал байгуулж, тэдгээр үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангах гол зорилт болж байна.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ
Зах зээлийн багтаамж	Судалгаагаар Ховд-УБ чиглэлийн нийтийн тээвэрт 40 гаруй ПАЗ маркийн 35 хүний суудалтай автобус жилдээ 20,0 мянга гаруй зорчигч, БаянӨлгий-УБ чиглэлийн нийтийн тээвэрт 30 гаруй тээврийн хэрэгсэл оролцож жилдээ 16,0 мянган хүн зорчиж байна. Иймд Дарви суманд автовокзал байгуулахад жилдээ 40,0 мянган зорчигч үйлчлүүлэх тооцоо гарч байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Ховд аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан байгаа.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	
Үйлдвэрлэлийн хүчин чадал	-авто буудлын байгууламж, тоног төхөөрөмж нь MNS 6300:2011 стандарт шаардлагын жагсаалтыг хангасан байх -зорчигч урсгалын өдрийн дундаж тоо /тухайн жилээр тооцно/ 250 хүн хүртэл -нэг цагт үйлчлэх хамгийн их зорчигчийн тоо 50 хүн хүртэл байх -авто буудлын үйлчилгээний талбай 50 м ² –аас багагүй байх -нийтийн зориулалтын талбай 75 м ² –аас багагүй байх -үйлчилгээний автобусны талбай нь 120 м ² –аас багагүй байх
Жилийн борлуулалтын тооцоолол	Судалгаагаар жилдээ 40,0 мянган зорчигч үйлчлүүлэх тооцоо гарч байна.
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Иргэдийн автотээврээр үйлчлүүлэх эрэлт хэрэгцээг хангаж, хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлсэн, хөдөлгөөний аюулгүй байдлын болон байгаль орчин, хүн амд сөрөг нөлөөгүй, орон нутгийн нийгэм эдийн засгийн нийтлэг эрх ашигт нийцсэн авто тээврийн оновчтой системийг бий болгоход чухал ачх олбогдолтой юм.

Ховд аймгийн Манхан сумын нутагт барих 60 МВт
дулааны цахилгаан станцын төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Манханы Дулааны цахилгаан станц
Байршил	Ховд аймгийн Манхан сумын нутагт
Үйлдвэрлэлийн хүчин чадал	60МВт
Төсөл хэрэгжүүлэх хугацаа	2015 оноос 2017 он хүртэл
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Хөшөөтийн уурхайн эрчим хүчний нүүрсийг ашиглаж 60 МВт-ын Дулааны цахилгаан станц барьж Хөшөөтийн нүүрсний уурхай, Алтай, Үенч, Булган сумын төв болон багуудыг эрчим хүчээр бүрэн хангахаас гадна Манхан сумын дэд станцыг өргөтгөж 110кВ-ын шугамаар Баруун бүсийн эрчим хүчний сүлжээнд холбоно. Дулааны эрчим хүчээр Манхан сумыг хангана.
Төслийн явц	ТЭЗҮ-нь боловсруулах шатандаа явагдаж байгаа.
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Хөшөөтийн уурхай нь 270,2 сая тонн нүүрсний нөөцтэй болох нь одоогоор тогтоогдоод байгаа учир удаан хугацаанд цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх боломжтой.
Зах зээлийн багтаамж	2013 онд 86.9 сая кВтц эрчим хүч ОХУ-аас, БНХАУ-аас 3.6 сая кВтц эрчим хүч худалдан авч байгаа бөгөөд цахилгаан эрчим хүчний хэрэглээ жилд 13-14 хувиар өсөж ирсэн байгаа нь судалгаанаас харагдаж байна. Цаашид бүс нутагт томоохон хэмжээний цахилгаан эрчим хүч их хэмжээгээр шаарддаг, уул уурхайн олборлох үйлдвэр болон хөнгөн үйлдвэрүүд байгуулагдана. Мөн төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдож цахилгаан эрчим хүчээ борлуулах бүрэн боломжтой.
Хууль эрх зүйн орчин	Монгол улсын УИХ, ЗГ, Эрчим хүчний яамнаас гаргасан Монгол улсын эрчим хүчний хөгжлийн хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан. Хөрөнгө оруулалт, Концесс, Эрчим хүчний болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.
Орон нутгийн дэмжлэг	Дулааны цахилгаан станц барих тал дээр орон нутгийн удирдлага болон ард иргэд бүрэн дэмжиж байгаа. Холбогдох зөвшөөрлийг саадгүй олгож, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын татварт хөнгөлөлт үзүүлж тогтвортой байдлын гэрээ байгуулан ажиллана.
Санхүүжилтийн хэлбэр	Концесс, Төр, хувийн хэвшил
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	ТЭЗҮ боловсруулах ажил бүрэн дуусаагүй тул санхүүжилтийн хэмжээ тодорхойгүй
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	Жишиг тооцоогоор 90.0 сая ам доллар
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээг өөрийн найдвартай өртөг бага эрчим хүчээр хангах. Цаашид бүс нутагт томоохон хэмжээний үйлдвэр үйлчилгээ, уул уурхай хөгжихөд түлхэц болно гэж үзэж байна. Манхан сумыг дулаанаар хангана.

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт Ховд гол дээр баригдах
Усан цахилгаан станцын төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станц
Байршил	Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт
Үйлдвэрлэлийн хүчин чадал	64 МВт
Төсөл хэрэгжүүлэх хугацаа	2015 оноос 2018 он хүртэл
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж Баруун бүсийн Ховд, Увс, Баян-Өлгий аймгийг бүрэн хангахаас гадна төвийн эрчим хүчний системтэй холбогдож бусад аймгуудыг эрчим хүчээр хангана.
Төслийн явц	Судалгаа хийгдэж, ТЭЗҮндэслэл нь бүрэн боловсруулагдсан.
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Жилд 230.0 сая кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ.
Зах зээлийн багтаамж	2013 онд 86.9 сая кВтц эрчим хүч ОХУ-аас, БНХАУ-аас 3.6 сая кВтц эрчим хүч худалдан авч байгаа бөгөөд жилд цахилгаан эрчим хүчний хэрэглээ 13-14 хувиар өсөж ирсэн байгаа нь судалгаанаас харагдаж байна. Цаашид бүс нутагт томоохон хэмжээний цахилгаан эрчим хүч их хэмжээгээр шаарддаг, уул уурхайн олборлох үйлдвэр болон хөнгөн үйлдвэрүүд байгуулагдана. Мөн төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдож цахилгаан эрчим хүчээ борлуулах бүрэн боломжтой.
Хууль эрх зүйн орчин	Монгол улсын Их Хурал, Засгийн газар, Эрчим хүчний яамнаас гаргасан Монгол улсын эрчим хүчний хөгжлийн хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан. Хөрөнгө оруулалт, Концесс, Эрчим хүчний болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.
Орон нутгийн дэмжлэг	Усан цахилгаан станц барих тал дээр орон нутгийн удирдлага болон ард иргэд бүрэн дэмжиж байгаа. Холбогдох зөвшөөрлийг саадгүй олгож, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын татварт хөнгөлөлт үзүүлж, тогтвортой байдлын гэрээ байгуулан ажиллана.
Санхүүжилтийн хэлбэр	Концесс, Төр, хувийн хэвшил
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	2007 онд боловсруулагдсан ТЭЗҮ-д 160.0 сая ам доллараар тусгагдсан тул төсвийн өртгийг нарийвчлан тооцоолох шаардлагатай.
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	2007 оны тооцооллоор 160.0 ам доллар
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ өөрийн найдвартай өртөг багатай, эрчим хүчээр хангах. Цаашид бүс нутагт томоохон хэмжээний үйлдвэр үйлчилгээ, уул уурхай хөгжихөд түлхэц болно гэж үзэж байна.

Ховд аймгийн жаргалант сумын Дулаан Цэвэр Бохир усны шугам сүлжээний шинэчлэлийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Жаргалант сумын Дулаан Цэвэр Бохир усны шугам сүлжээний шинэчлэл
Байршил	Ховд аймгийн Жаргалант сум
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилдээ 1309,2 мянган м3 цэвэр ус олборлон түгээж, 1112,8 мянган м3 бохир ус татан зайлуулдаг. Мөн орон сууцны дулааны шугам сүлжээний засвар үйлчилгээ
Төсөл хэрэгжүүлэх хугацаа	2015 оноос 2017 он хүртэл
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Жаргалант сумын хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах хуучирч муудсан төв болон салбар шугамыг шинэчлэн засварлах. Одоогоор Жаргалант сумын хэмжээнд 2500 гаруй айл өрх, 150 гаруй албан байгууллагууд дээрх шугам сүлжээг ашиглаж байгаа нь эдгээр хуучирч муудсан шугам сүлжээг шинэчлэх шаардлагатай байгааг харуулж байгаа юм.
Төслийн явц	ТЭЗҮ хийгдсэн, одоогоор хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай байгаа
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Дулаан, Цэвэр, Бохир усны шугам сүлжээ угсрах
Зах зээлийн багтаамж	Жаргалант сумын 2500 орчим айл өрх, 150 гаруй аж ахуй нэгжийг цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулхаас гадна гэр хорооллын ус түгээх цэгээр дамжуулан 3200 айл өрхөд цэвэр ус түгээж байна.
Хууль эрх зүйн орчин	Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 6.1.2 болон тус хуулийн 8.1.2
Орон нутгийн дэмжлэг	Жаргалант сумын Дулаан Цэвэр Бохир усны шугам сүлжээний шинэчлэлийн тал дээр орон нутгийн удирдлага болон ард иргэд бүрэн дэмжиж байгаа. Холбогдох зөвшөөрлийг саадгүй олгож, татварт хөнгөлөлт үзүүлж тогтвортой байдлын гэрээ байгуулан ажиллана.
Санхүүжилтийн хэлбэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон, концессийн гэрээгээр
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	450.0 сая төгрөг
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	450.0 сая төгрөг
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Жаргалант сумын хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах.

**Мөнххайрхан- Хуурай Сэнхэр чиглэлийн хайрган хучилттай
авто зам барих төслийн товч танилцуулга**

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Мөнххайрхан- Хуурай Сэнхэр чиглэлийн хайрган хучилттай авто зам
Байршил	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын Ховд-Манхан чиглэлийн 75 дэх км заалтаас салж, Хуурай Сэнхэрээр 52 км урт хайрган хучилттай авто зам
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Ховд-Мөнххайрхан чиглэлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, техникийн шаардлагад нийцсэн хайрган хучилттай замтай болноор алслагдсан бүс нутгийн хөгжилд түлхэц өгнө.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Ховд – Мөнххайрхан чиглэлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, техникийн шаардлагад нийцсэн хайрган хучилттай зам
Зах зээлийн багтаамж	Судалгаагаар жилдээ орон нутгийн иргэд, байгууллагын 1500 тээврийн хэрэгсэл зорчсонгооцоо байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгийн иргэд, төрийн захиргааны байгууллага бүрэн дэмжиж байна. Холбогдох зөвшөөрөл саадгүй олгож, хамтран ажиллах санал санаачлагыг дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Концесс, төр, хувийн хэвшил
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	Урьдчилсан тооцоогоор 10,0 тэрбум төгрөг
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	Урьдчилсан тооцоогоор 10,0 тэрбум төгрөг
Үйлдвэрлэлийн хүчин чадал	52 км урт, зорчих хэсгийн өргөн 7 м
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Иргэдийн авто тээврийн эрэлт хэрэгцээг хангаж, хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлсэн, хөдөлгөөний аюулгүй байдлын болон байгаль орчин, хүн амд сөрөг нөлөөгүй, орон нутгийн нийгэм эдийн засгийн нийтлэг эрх ашигт нийцсэн авто тээврийн оновчтой системийг бий болгоход чухал ач холбогдолтой юм.

Эрдэс шилэн хөвөнгийн үйлдвэр байгуулах
төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Эрдэс шилэн хөвөнгийн үйлдвэр
Байршил	Аймгийн төв үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Барилгын дулаалганы материал эрдэс шилэн хөвөн үйлдвэрлэх. Баригдаж байгаа барилга байгууламжийн дулаан алдагдлыг багасгаж агаарын бохирдлыг бууруулах
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	0,5 мм зузаантай, эзэлхүүний нягт 100-125Кг/метр куб, Чийг 0,4 % Дулаан дамжуулалтын итгэлцүүр 0,0400-0,42, Вт/мС, Шахалтын бат бэх 0,24 МПа, Шатах хугацаа-шатахгүй
Зах зээлийн багтаамж	Ховд хотод барилга байгууламж эрчимтэй хөгжиж байгаа ба барилгын дулаан алдагдыг бууруулахад эрдэс шилэн хөвөнг импортоор их хэмжээгээр оруулж ирэн ашиглаж байна. Цаашид баруун аймгуудын барилгын дулаалгын эрдэс шилэн хөвөнгийн хэрэгцээг хангах боломжтой.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Засгийн газрын “100 мянган орон сууц” хөтөлбөрийн хүрээнд барилгын материалын үйлдвэрийг дэмжиж байгаа.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	Тооцоолол хийгдээгүй байгаа
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	
Үйлдвэрлэлийн хүчин чадал	
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Барилгын ажил улирлын чанартай учраас барилга угсралтын компаниудад цаг хугацаа хүн хүч хэмнэх сайн талтай. Ховд аймагт үйл ажиллагаа явуулж байгаа барилга угсралтын компаниуд стандартын шаардлага хангасан эрдэс шилэн хөвөн дулаалгын материалыг ашигласнаар дулаан алдагдал багатай барилга байгууламж зах зээлд нийлүүлж агаарын бохирдлыг бууруулна.

Шилний үйлдвэр төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Шилний үйлдвэр
Байршил	Ховд аймгийн жаргалант сумын нутагт
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Тооцоолол сайн хийгдээгүй
Төсөл хэрэгжүүлэх хугацаа	2015 оноос 2017 он хүртэл
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Сав савалгааны болон бусад шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх. Үүнтэй холбоотой сав савалгааны , барилга байгууламжын цонх хаалганы шилийг тээвэрлэхэд ашиг багатай хохирол учирах магадлал ихтэй иймээс шилийг дотооддоо үйлдвэрлэх .
Төслийн явц	Судалгааны шатандаа
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Шил, шилэн бүтээгдэхүүн
Зах зээлийн багтаамж	Ховд аймагт шил үйлдвэрлэхэд Ордог үндсэн түүхий эд болох цахиурын агууламж өндөртэй элсны орд газар байдаг. Иймээс уг үйлдвэр барьж баруун бүс нутгийн хэмжээнд бүтээгдэхүүнээ борлуулах бүрэн боломжтой. Мөн барилга байгууламж хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжиж байгаатай холбогдон шил, шилэн бүтээгдэхүүний хэрэгцээ ихсэж байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалт, Концесс, болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.
Орон нутгийн дэмжлэг	Үйлдвэрлэлийн бүсэд газар олгоно. Холбогдох зөвшөөрлийг саадгүй олгож, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын татварт хөнгөлөлт үзүүлж тогтвортой байдлын гэрээ байгуулан ажиллана.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн хэвшил
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Орон нутгийг шил шилэн бүтээгдэхүүнээр бүрэн хангаж тээвэрлэлтээс болж гардаг алдагдал үгүй болно.